

“Торгоны зам эдийн засгийн бүс дагуух улсуудад зориулсан цөлжилттэй тэмцэх сургалт”-д оролцлоо

Цөлжилтийг Сааруулах Олон Улсын Сургалт, Судалгааны төв (UNEP-CAS), Цөлжилтийн Судалгааны Олон улсын Холбоо (IDRA), БНХАУ-ын Шинжлэх Ухааны академийн Баруун хойд бүсийн Хүрээлэн буй орчин, Нөөцийн хүрээлэнгээс (NIEER) хамтран зохион байгуулсан “Торгоны зам эдийн засгийн бүс дагуух улсуудад зориулсан цөлжилттэй тэмцэх сургалт” 2023 оны 7 сарын 23-аас 8 сарын 05 хүртэл хугацаанд БНХАУ-н Бээжин хотод болж өнгөрөв. Онол, практик хосолсон тус сургалтад Америк, Япон, Монгол, Хятад, Пакистан, Иран, Киргиз, Орос, Казакстан, Этиоп, Рванда зэрэг улсуудаас төлөөлөн судлаачид оролцлоо. Монгол улсаас Газарзүй, Геоэкологийн хүрээлэнгийн Цөлжилтийн судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан Д.Отгонцэцэг, Б.Оюундарь нар хамрагдлаа.



Сургалтын хүрээнд цөлжилт, газрын доройтол, шар шороон шуурга, элсний нүүлт хөдөлгөөний чиглэлээр мэргэшсэн судлаач эрдэмтэд онолын лекц өгч, оролцогч орнуудын судлаачид өөрийн улсад явуулж буй судалгаа, хэрэгжүүлж буй технологийн тэргүүн туршлагаудаасаа хуваалцлаа.



Мөн БНХАУ-ын Цөлжилттэй тэмцэх үйл ажиллагаатай танилцах зорилгоор ӨМӨЗО-ы Найман мужид байрлах Найманы цөлжилттэй тэмцэх туршилт судалгааны сууринд очиж ажиллалаа. Тус төв нь Хорчин элсэрхэг бүс нутагт байрлах бөгөөд элсэн манхан зонхилсон, хур тунадас, температурын өндөр хэлбэлзэлтэй, жилийн нийлбэр хур тунадас 350-500 мм хүрдэг, жилийн дундаж ууршилт 1500-2500 мм бүхий онцлогтой газар нутаг юм. Энд 1970 оны сүүлээс эхлэн цөлжилтийн үйл явцад онцгой анхаарал хандуулж эхэлсэн бөгөөд энэ суурин судалгааны төвийг түшиглэн дараах үйл ажиллагааг явуулдаг. Үүнд:

- цөлжилтийн тэлэх үйл явцыг судлах,
- элсэрхэг газрын экосистемийн бүтэц, үйл ажиллагаа, менежмент,
- доройтсон экосистемийг нөхөн сэргээх биологийн үндэс,
- элсэрхэг газрын усны тэнцвэрийг хадгалан хамгаалж түүний нөөцийг ашиглах,
- байгалийн нөөцийн урт хугацааны мониторинг судалгаа,
- уур амьсгалын өөрчлөлт болон органик нүүрстөрөгчийн хэлбэлзэл зэрэг судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна.

Бид хээрийн аяллын хугацаанд хэд хэдэн технологийн шийдлүүдтэй танилцаж туршлага судлав.



Найман цөлжилтийг сааруулах туршилт судалгааны төвд байгуулсан ургамал-хөрс-усны ажиглалт хийх систем. Энэхүү байгууламжаар дамжуулан ургамал бүрхэвч хөрсний чийгийг тогтоон барих чадвар болон үндэсний өсөлтийг судалдаг.




Элсэрхэг хөрстэй газарт тохиромжтой ургамлуудыг тарьж амьжиргаагаа дэмждэг. Газрын самар болон давжаа алимьг тус талбайд сэлгэн тарьсан байна.



Элсний нүүлтийг сааруулах механик хамгаалалтыг төв зам дагууд хийсэн байдал.



Элсэрхэг газар бүхий газрыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлжээ.



Элс ашиглан замын хавтан үйлдвэрлэж ашиглаж байна. Энэ материал нь борооны усыг шингээх бөгөөд доороо хуримтлуулах савыг байгуулан дахин ашиглах боломжтой байна.